

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 66.2 дахь заалт, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн хурлын зар мэдээг хүргэх, санал авах тухай” журмыг хавсралтад дурдсанаар баталсугай.
2. Журмыг нийтэд сурталчлахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

## **ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУРЛЫН ЗАР МЭДЭЭГ ХҮРГЭХ, САНАЛ АВАХ ТУХАЙ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зар мэдээг хүргэх, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах болон хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

### **ХОЁР. Хуралд оролцох эрх**

2.1. Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл ээлжит бус хурал зарлах эрх бүхий этгээд нь хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргана.

2.2. Уг шийдвэрт дараахь зүйлийг заана:

- 1)хурал хуралдах газар, өдөр, цаг;
- 2)хурлаар хэлэлцэх асуудал;
- 3)хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр;
- 4)хуралд бэлтгэх явцад хувь нийлүүлэгчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, цаг;
- 5)санал авах хуудсын агуулга;
- 6)санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн өдөр;
- 7)хурал хуралдуулах тухай хувь нийлүүлэгчдэд мэдээлэх өдөр.

2.3. Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэх өдөр”-ийг хурал хуралдуулах тухай мэдээлсэн өдрөөс хойш 4 дэх хоногоор тогтооно.

2.4. Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор “хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл”-ийг 1 дүгээр хавсралтаар Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржид ирүүлнэ.

2.5. Хөрөнгийн биржийн холбогдох албаас “бүртгэх өдөр”-өөр тасалбар болгон гаргасан хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтанд орсон хувь нийлүүлэгч нь хуралд оролцох эрх эдэлнэ.

2.6. Хувь нийлүүлэгч нь Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хуралд оролцож болно.

2.7. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа хурал эхлэхээс өмнө Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдсэн байна.

2.8. “Бүртгэх өдөр”-өөс хойш бусдаас хувьцаа шилжүүлэн авсан этгээд хуучин эзэмшигчийн бичгээр олгосон итгэмжлэлийн дагуу хуралд оролцож болно.

## **ГУРАВ. Хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах**

3.1. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх эрхтэй.

3.2. Энэ эрхээ эдлэхийн тулд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшсэн этгээд ийнхүү өмчлөх эрх үүссэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Үнэт цаасны хороонд бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд дараахь зүйлийг тусгана:

- 1/ямар компанийн хувьцааг эзэмшиж байгаа;
- 2)өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, регистрийн дугаар, ямар учраас нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцож байгаа тухай тайлбар;
- 3)нэгдмэл сонирхолтой этгээдийг төлөөлөх этгээдийн нэр, шуудангийн хаяг, утасны дугаар.

3.3. Компани нь энэхүү мэдэгдлийн дагуу нийт гаргасан энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн бүртгэл хөтөлнө.

3.4. Компанийн ТУЗ нь хувь нийлүүлэгчдийн хурал хуралдахаас 60-аас доошгүй хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх санал ирүүлэх тухай мэдэгдлийг 5-аас дээш хувийн энгийн хувьцаа эзэмшигчдэд бичгээр хүргүүлнэ.

3.5. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч хувь нийлүүлэгчид нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45-аас доошгүй хоногийн өмнө хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх саналаа компанийн ТУЗ-д бичгээр ирүүлнэ.

3.6. Уг саналд дараахь зүйлсийг тусгана:

- 1)гаргаж байгаа санал, түүний шалтгаан;
- 2)санал оруулж буй хувь нийлүүлэгчийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, тэдний эзэмшилд байгаа хувьцааны тоо;
- 3)хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлбэл нэр дэвшигчийн овог, нэр, нэр дэвшүүлсэн шалтгаан, товч намтар.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь дор дурдсанаас бусад тохиолдолд хувь нийлүүлэгчийн гаргасан саналыг хурлын зарыг хувь нийлүүлэгчдэд хүргэхээс өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.

- 1)санал гаргагч нь энэ журмын 3.1-д заасан болзлыг хангаагүй;
- 2)ирүүлсэн саналдаа 3.6-д заасан мэдээллийг тусгаагүй.

3.8. ТУЗ нь нэмэлт саналыг хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулах, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал гаргасан хувь нийлүүлэгчид бичгээр хүргүүлнэ.

3.9. Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарч хурлыг нийтэд зарласнаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

### **ДӨРӨВ. Хурлын зар мэдээг хувь нийлүүлэгчдэд хүргэх**

4.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хурал зарлах эрх бүхий этгээд, энэ журмын гуравдахь хэсэгт заасны дагуу хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт гаргасны дараа хурлын тухай зар мэдээг хувь нийлүүлэгчдэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

4.2.Хурлын тухай мэдээллийг хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэнэ.

4.3.Хурлын тухай зар мэдээнд компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, бүртгэх өдөр, хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам зэргийг тусгасан байна.

4.4.Хувь нийлүүлэгчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг Хөрөнгийн биржтэй байгуулсан гэрээний дагуу бирж зохион байгуулж байгаа бол хурлын баримт бичиг, саналын хуудсыг хурлын тухай зар мэдээг олон нийтэд хүргэхээс 7-гоос доошгүй хоногийн өмнө Хөрөнгийн биржид ирүүлсэн байна.

4.5.Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зар мэдээг нийтэд зарлах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө, бүртгэх өдрөөр тасалбар болгон гаргасан хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтын дагуу санал авах хуудсыг хурал хуралдахаас 20-иос доошгүй хоногийн өмнө тус тус орон нутаг дахь Үнэт цаасны компанид хүргүүлсэн байна.

4.6.Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэсэн үед хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг, санал авах хуудсыг бэлэн болгосон байх бөгөөд хувь нийлүүлэгчдэд түүнтэй танилцах боломжийг компанийн ТУЗ хангасан байна.

4.7.Компанийн ээлжит бус хурлыг эрх бүхий этгээд зарлан хуралдуулж байгаа тохиолдолд, журмын 3.4 болон 4.2; 4.3-т заасан ТУЗ-ийн үүргийг нэгэн адил хүлээнэ.

4.8.Хувь нийлүүлэгчдэд дараахь баримт бичгийг танилцуулна.

- 1)компанийн жилийн санхүүгийн тайлан;
- 2)санхүүгийн тайлангийн талаар аудиторын дүгнэлт;
- 3)өмнөх санхүүгийн жилд хийсэн сонирхлын зөрчил бүхий болон их хэмжээний хэлцлүүд, тэдгээр нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн тухай аудиторын дүгнэлт;
- 4)ТУЗ-д болон хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- 5)нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдний эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;
- 6)төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх
- 7)компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан;
- 8)компанийн хяналтын зөвлөлийн тайлан;
- 9)шинээр болон нэмж үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол гаргах үнэт цаасны төрөл, тоо, нэрлэсэн үнэ, санхүүжилтийн зориулалтын талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн

хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувь нийлүүлэгчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

### **ТАВ. Хувь нийлүүлэгчдийн санал авах**

5.1.Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарах шийдвэрт өгөх саналыг саналын хуудсаар авна. Санал авах хуудсын үлгэрчилсэн загварыг журмын хавсралт болгон гаргав.

5.2.Хуралд биеэр оролцох боломжгүй хувь нийлүүлэгчид өөрийн харилцдаг Үнэт цаасны компани дээр очиж хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж хурлаас гаргах шийдвэрийн төсөлд өгөх саналаа саналын хуудаст тэмдэглэнэ.

5.3.Саналын хуудсын загварыг Төлөөлөн удирдах зөвлөл батална. Энэ нь дараахь бүрдүүлбэртэй байна:

- 1)компанийн оноосон нэр;
- 2)хурал хийх газар, өдөр, цаг;
- 3)хувь нийлүүлэгчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;
- 4)санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томьёолол, Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн овог, нэр.

5.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар “зөвшөөрсөн”, “татгалзсан” алин болохыг саналын хуудаст тэмдэглэнэ.

5.5. Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Уг аргаар санал хураахад хувь нийлүүлэгч бүрийн саналын эрхийн тоо нь эзэмшиж буй хувьцааны тоог Төлөөлөн удирдах зөвлөлд сонгох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Хувь нийлүүлэгч нь саналаа нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгох саналтай нэг, хоёр, гурав гэх мэтчилэн хэдэн ч хүнд өгч болно. Нийт өгсөн саналын тоо нь өөрийн эзэмшиж буй саналын тооноос хэтрээгүй, санал өгсөн нэр дэвшигчийн тоо нь ТУЗ-д сонгогдох хүний тооноос хэтрэхгүй байна. Сонгох саналтай нэр дэвшигчийн нэрийн ард тухайн нэр дэвшигчид өгөх өөрийн саналын тоог тэмдэглэнэ.

5.6. Үнэт цаасны компани хурал зарласан хувьцаат компаниас ирүүлсэн саналын хуудсыг дагалдах албан бичигт дурдсан тоотой тулган тоолж шалгаад, тусгай дэвтэрт тэмдэглэн хүлээж авна. Хувь нийлүүлэгчид саналын хуудас болон хурлаас гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангах бөгөөд саналын хуудсыг компани ирүүлсэн бичигт дурдсан хугацаанд, гэхдээ хурал хуралдахаас 7-гоос доошгүй хоногийн өмнө дагалдах бичгийн хамт компанид явуулна. Дагалдах бичигт нийт хүлээж авсан саналын хуудасны тоо, үйлдсэн саналын хуудасны тоо, санал өгсөн хувь нийлүүлэгчдийн эзэмшиж буй нийт хувьцааны төрөл, тоо зэргийг зааж компанийн эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

5.7.Саналаа ирүүлсэн хувь нийлүүлэгчийн саналын хуудас нь Компанийн тухай хуульд заасны дагуу хүчинтэй тохиолдолд уг хувь нийлүүлэгчийг хуралд оролцсон гэж тооцно.

5.8.Хуралд биеэр болон итгэмжилсэн этгээдээр төлөөлүүлэн оролцож буй хувь нийлүүлэгч хурлын явцад саналын хуудсаа үйлдэн тооллогын комисст өгнө. Саналын хуудас үйлдэх журам нь адилхан байна.

**ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО**

“Хувьцаат компанийн хурлын зар мэдээ хүргэх,  
санал авах тухай” журмын 1 дүгээр хавсралт

## ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр .....

Хаяг, утас .....

Хувь нийлүүлэгчдийн ээлжит /ээлжит бус/ хурал /алин болохыг доогуур нь зур/  
Хурал хуралдах огноо, цаг, газар .....

.....

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо .....

Олон нийтэд зарлах огноо .....

Бүртгэх өдөр .....

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг Хөрөнгийн биржид хүргүүлэх огноо .....

Хүргүүлсэн огноо .....

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ..... ширхэг, ..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН ДАРГА .....

..... оны .... дүгээр сарын ..... –ний өдөр

.....

ХҮЛЭЭН АВСАН :  
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН .....

..... оны .... дүгээр сарын ..... –ний өдөр

- .....
1. Хурлын зарыг “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Монголын мэдээ” гэх зэрэг өдөр тутмын сонинд заавал зарлахын зэрэгцээ үндэсний радио, телевизээр зарлана.
  2. Бүртгэх өдрөөр хувьцаа эзэмшиж байгаа гишүүд хуралд оролцоно.
  3. Энэхүү мэлээллийг 2 хувь үйлдэж Үнэт цаасны хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус ирүүлнэ.

“Хувьцаат компанийн хурлын зар мэдээ хүргэх,  
санал авах тухай” журмын 2 дугаар хавсралт

САНАЛ АВАХ ХУУДАС  
..... ХК

Хувьцаа эзэмшигч ..... овогтой .....  
Регистрийн дугаар ..... эзэмшиж буй хувьцааны төрөл .....  
/Энгийн, давуу/ хувьцааны тоо ..... кумулятив аргаар өгөх саналын тоо .....  
Хувь нийлүүлэгчдийн ээлжит /ээлжит бус/ хурал /алин болохыг доогуур нь зур/  
..... оны ..... сарын ..... –ны өдрийн ..... цагт ..... болно.  
/Хурал хийх газар/

Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Нэр дэвшигчид өгөх саналыг тоо
Компанийн ..... оны санхүүгийн тайланг батлах			
Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах			
Гэх мэт			
ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид			
1. _____ 2. _____ 3. _____ 4. _____ 5. _____ 6. _____ 7. _____ 8. _____ 9. _____ 10. _____ 11. _____ .....			
Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид 1. _____ 2. _____ 3. _____ 4. _____ .....			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

..... /...../

Санал авах хуудсыг үйлдсэн ..... оны ..... сарын .....-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон тооллогын комиссын дарга

..... /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: .....